ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 01 сарын 26 өдөр Дугаар 01 Улаанбаатар хот

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр
2026-2027 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)-г
шинэчлэн батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.8.2 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам"-ын 3.1 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын 5.1, 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2026-2027 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-г нэгдүгээр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрэх үр дүнг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-г хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга Б.Алимаа, үйл ажиллагаа (хөтөлбөр)-ны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Д.Ренчиндорж, хэрэгжилтийг ил тод нээлттэй, хурдан шуурхай зохион байгуулан хяналт тавьж, шалгуур үзүүлэлтийн дагуу үр дүнг тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Бауыржан, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Д.Гэрэл, Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн захирал М.Батгэрэл нарт тус тус даалгасугай.

3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-г хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн гишүүд, аймаг, дүүргийн зөвлөлд тус тус даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Т.АУБАКИР

УЛААНБААТАР ХОТ
ХЭҮЗ
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ
ТТГ № 4565

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2026
оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 01 дүгээр
тогтоолын нэгдүгээр хавсралт

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР 2026-2027 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА (ХӨТӨЛБӨР)

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, үйлчилгээ, арга хэмжээг зорилтот бүлэгт зориулан тухайн иргэний хэрэгцээ, шаардлагад үндэслэн сонгон хэрэгжүүлнэ.

1.2. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь үйлчилгээ, арга хэмжээг Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр тодорхойлсон, тусгайлан баталсан хөтөлбөр[1], "Цагаан алт", "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх зорилт, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн онцлогт нийцүүлэн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл болон ядуурлыг бууруулах зорилготой уялдуулан хэрэгжүүлэх бөгөөд хууль дэдлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, ил тод нээлттэй, шуурхай байх зарчмыг баримтална.

1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, үйлчилгээ, арга хэмжээ (цаашид "арга хэмжээ" гэх)-ний хамрах хүрээ:

1.3.1. ажилгүй иргэн;
1.3.2. ажил олоход хүндрэлтэй иргэн;
1.3.3. ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн;
1.3.4. ажил хайгч иргэн;
1.3.5. бага орлоготой өрхийн гишүүн;
1.3.6. хорих ангиас суллагдсан иргэн;
1.3.7. Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.8-д заасан иргэн;
1.3.8. түр болон цагийн хөдөлмөр эрхэлдэг оюутан залуучууд;
1.3.9. ахмад настан;
1.3.10. хөгжлийн бэрхшээлтэй хүн;
1.3.11. хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүүхдийг асарч буй хүн;
1.3.12. хөгжлийн бэрхшээлтэй хүний үүсгэн байгуулж, үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага;
1.3.13. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах, хамтран ажиллах шаардлага хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага.

1.4. Тавигдах ерөнхий шаардлага:

1.4.1. арга хэмжээнд хамрагдах хүсэлтээ ирүүлсэн хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага нь зохистой хөдөлмөр эрхлэлтийн шаардлагыг хангасан, албан эдийн засгийн салбарт ажилладаг байх нь давуу талтай байна; /Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Татварын ерөнхий хууль, Хөдөлмөрийн болон бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилгүй байх/

[1] Энэхүү хөтөлбөрийн 9.1.1-д заасан хөтөлбөрүүд.

1.4.2. арга хэмжээг гэрээлэн гүйцэтгэх хувь хүн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллага нь тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэх мэргэжлийн болон зөөлөн ур чадвар, ажлын туршлагатай, хүний нөөц, шаардлагатай тоног төхөөрөмж, барилга байгууламжийн чадавхтай байх;

1.4.3. оролцогч талууд нь ногоон ажлын байрыг дэмжсэн, эрхэлж буй бизнес үйл ажиллагаагаа ногоон эдийн засаг[2] руу шилжүүлэх хүсэл эрмэлзэлтэй, төлөвлөгөөтэй байх;

1.4.4. бүх төрлийн сургалтын үйл ажиллагаанд ногоон ур чадвар[3] олгох агуулгыг оруулсан байх;

1.4.5. оролцогч талууд арга хэмжээг хэрэгжүүлж буй төрийн захиргааны байгууллагаас зохион байгуулсан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэх тухай соён гэгээрүүлэх сургалтад хамрагдсан байх;

1.4.6. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2026 оныг "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан үйл ажиллагаа, арга хэмжээг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил"-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлэх.

ХОЁР. НЭР ТОМЬЁО, ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ

Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд ашиглагдаж буй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заагаагүй дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно.

2.1. Ажлын байрны дадлагажуулагч (Job Coaching)

Ажлын байран дээр аж ахуйн нэгж байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг холбон ажиллах, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй, зохих арга зүйг эзэмшсэн хүнийг хэлнэ.

2.2. Байнгын ажлын байр

Ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын доор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч байгаа, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил үүргийг хэлнэ.

2.3. Гарааны бизнес (Start-up)

Инновацыг хөгжүүлэх замаар хэрэглэгчдэд хүртээмжтэй, үнэ цэнтэй шийдэл бүтээх, тогтвортой ажиллах системийг төлөвшүүлэх зорилготой цогц үйл ажиллагааг хэлнэ.

2.4. Дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлт (Supported employment)

Хөгжлийн бэрхшээлийн төрөл, хүндрэл зэргээс үл хамааран ажлын байранд шаардагдах ур чадварыг аажмаар олгож, хэрэгцээ шаардлагад нь нийцсэн ажлын байрны тохируулга хийх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийг хэлнэ.

2.5. Зорилтот ажлын байранд ажиллуулах

Хөгжлийн бэрхшээлийн онцлогоос шалтгаалан ажил, хөдөлмөр эрхлэх боломжгүй иргэдийг нийгэмшүүлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажил хөдөлмөрийн ойлголт,

---

[2]Байгаль орчинд ээлтэй, нөөцийг үр ашигтай ашигладаг, нүүрстөрөгч багатай бөгөөд тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмждэг эдийн засгийн хөгжил юм. *Эх сурвалж:ILO & UNEP (2008). Green Jobs: Towards Decent Work in a Sustainable, Low-Carbon World*

[3] Ногоон ажлын байрыг бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг тогтвортой болгох, байгаль орчны доройтлыг бууруулахад шаардлагатай техникийн болон ерөнхий ур чадварууд юм. *Эх сурвалж: ILO (2011). Skills for Green Jobs: A Global View.International Labour Organization.*

ажил хөдөлмөрийн анхан шатны дадал суулгах зорилгоор зохион байгуулж, тэдэнд зориулсан ажлын байр бий болгох арга хэмжээ, үйл ажиллагааг хэлнэ.

2.6. Тохируулгатай ажлын байр (Workplace adjustment)

Хөгжлийн бэрхшээлтэй хүний бэрхшээлийн онцлог хэрэгцээнд тулгуурлан ажиллах орчин нөхцөл, материал, тоног төхөөрөмжийг бий болгон ажлын байраар хангах явцыг хэлнэ.

2.7. Түр ажлын байр

Хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил, үйлчилгээг хөдөлмөрийн ба хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээг үйл ажиллагааны онцлогоос хамааран 6 сар хүртэлх хугацаагаар байгуулж, тодорхой нэг ажил үүргийг гүйцэтгэснээр дуусгавар болдог, байнгын давтамжгүй тохиолдлын шинж чанартай ажил үүрэг, албан тушаалыг хэлнэ.

2.8. Түр ажилтан

Хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил, үйлчилгээг хөдөлмөрийн ба хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээг үйл ажиллагааны онцлогоос хамааран 6 сар хүртэлх хугацаагаар байгуулж, цалин хөлс, орлого олдог, эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарах, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг өөрөө бие даан хариуцаж төлдөг иргэнийг хэлнэ.

2.9. Хөдөлмөрийн нөхөн сэргээлт

Өвчин, осол, гэмтлийн улмаас хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн буюу бүрэн алдаж эрүүл мэндийн магадлалын зөвлөлөөр хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүнд өмнө хийж байсан эсхүл шинэ ажил мэргэжлийн дадал олгох, ажилбар хийж гүйцэтгэхэд болон хөдөлмөрийн зах зээлд нэвтрүүлэх, дахин ажил хөдөлмөр эрхлэх боломжийг нь сэргээхэд чиглэсэн арга хэмжээ, үйл ажиллагааг хэлнэ.

2.10. Хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх

Хүн бүрийн боломж, чадварт тохирсон ажилд зуучлах, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шаардлагатай дэмжлэг үзүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааг хэлнэ.

2.11. Хөдөлмөр эрхлэх чадвар (Employability)

Хүний онцлог шинж чанар буюу дасан зохицох чадвар, ажил мэргэжилд чиглэсэн сонирхол, чадавхаа таньж мэдсэн байдал, хөдөлмөр эрхлэх чадавх боломж (мэдлэг, чадвар, ажлын туршлага, нийгмийн сүлжээ г.м) зэргээс бүрдэнэ.

2.12. Шинэ ажлын байр

Эдийн засгийн үйл ажиллагааны хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээ бий болгох болон өргөтгөх замаар албан ба албан бус салбарт шинээр бий болсон ажил, үүрэг, албан тушаалыг хэлнэ.

ГУРАВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, удирдлага арга зүйгээр хангаж, хяналт тавьжажиллана.

3.2. Арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэгч байгууллагууд нь энэхүү тогтоол болон тогтоолын хавсралтыг үндэслэн үйл ажиллагаагаа зохион байгуулна.

3.3. Арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэн ажиллаж буй байгуулага нь тухайн арга хэмжээний танилцуулга, мэдээлэл, зарыг өөрийн цахим сувгаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлаар олон нийтэд тогтмол мэдээлнэ.

3.4. Арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болох бөгөөд сонгон шалгаруулалтын баримт бичгийн төсөлд шаардлагатай тохиолдолд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал авч хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

3.5. Арга хэмжээг хариуцан зохион байгуулж буй байгууллага нь 3.4-д заасан гэрээнд хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгах бөгөөд гэрээний хэрэгжилтийг дүгнэж, гүйцэтгэлийн үр дүнгээр гэрээнд заасан нөхцөлөөр санхүүжилтийг олгоно.

3.6. Арга хэмжээг зохион байгуулж буй байгууллагын даргын тушаалаар сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг байгуулна. Ажлын хэсэг нь төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн байх бөгөөд хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар баталсан ажлын хэсэгт хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын оролцоог заавал хангана. Төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөлд олгох ажлын хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 30 хувиар тооцож олгоно.

3.7. Арга хэмжээг зохион байгуулж буй байгууллага нь санхүүгийн дэмжлэг авсан иргэн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж ажиллана.

3.8. Арга хэмжээний хэрэгжилтийн мэдээллийг зохион байгуулагч тал хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн нэгдсэн систем /e-job/-д тогтмол оруулна.

3.9. Арга хэмжээний хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг энэхүү тогтоолын хоёрдугаар дугаар хавсралтаар баталсан загвар, үзүүлэлтээр тооцох бөгөөд энэхүү үнэлгээ нь гүйцэтгэгч байгууллагын гэрээг дүгнэх үзүүлэлт, мөн дахин хамтран ажиллах үндэслэл болно.

3.10. Арга хэмжээний хэрэгжилтийн мэдээ, тайланг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан загварын дагуу сар бүрийн 10-ны дотор тус яаманд ирүүлнэ.

3.11. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2026-2027 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа (хөтөлбөр)-г батлагдсан өдрөөс хойш 14 хоногийн дотор хэрэгжүүлж эхэлнэ. Төрийн захиргааны байгууллагууд холбогдох удирдамж, гэрээний загвар, сонгон шалгаруулалтын баримт бичгийг баталж, иргэдэд мэдээллийг шуурхай хүргэнэ.

3.12. Арга хэмжээний зардлыг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан төсвийн хуваарийн дагуу хууль, тогтоомжид нийцүүлэн зарцуулна.

3.13. Арга хэмжээний үр нөлөөний үнэлгээг Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн хариуцан зохион байгуулна.

ДӨРӨВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан болон Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс тусгайлан баталсан хөтөлбөр[4], "Цагаан алт" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх зорилт, хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан зохион байгуулах бөгөөд үйлчилгээ үзүүлэх байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн систем(www.ejob.gov.mn)-ийг ашиглана.

[4]Энэхүү хөтөлбөрийн 9.1.1, 9.1.3-д заасан хөтөлбөрүүд.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг дараах төрлөөр хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ

4.1.1. ЕБС-ийн ахлах анги, МБСБ, Их сургууль, коллежийн суралцагч, төгсөгч, ажилгүй болон ажил хайгч иргэдэд ажил мэргэжлийн сонголт, хөдөлмөрийн зах зээлийн боломж, үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр зөвлөгөө өгнө. Хэрэгжүүлэхдээ ГБХНХ-ын сайдын баталсан стандарт болон MNS 6620:2016 стандартыг мөрдөнө.

4.1.2. хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн хувийн бирж нь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг зохион байгуулах бөгөөд ажлын ярилцлага, асуулгад бэлтгэх, ажлын байртай танилцуулах[5] ажлыг зохион байгуулж болно.

4.1.3. ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд хамрагдах ЕБС-ийн ахлах ангийн суралцагчдын эзлэх хувь нь хувийн хөдөлмөрийн биржид 20 хувиас, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 40 хувиас тус тус хэтрэхгүй байна.

4.2. Ажилд зуучлах үйлчилгээ

4.2.1. ажил хайж байгаа иргэнд хүсэл сонирхол, мэргэжил, ур чадварт нь тохирсон ажил, ажил олгогчид эрэлт хэрэгцээнд нь нийцсэн ажилтан тус тус олоход нь туслалцаа үзүүлэх үйлчилгээ байна. Тодруулбал, профайлинг (хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ), хувийн төлөвлөгөө боловсруулах, ажилд зуучлах (байнгын/түр/цагийн гэх мэт), эргэх холбоо, дагалдан ажиллахад үзүүлэх дэмжлэг болно.

4.2.2. ажилд зуучлах үйлчилгээнд хамрагдах иргэнийг олон улсын байгууллагын тусламжаар хэрэгжүүлж буй туршилтын төслийн[6] хөдөлмөр эрхлэлтийн зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр өөрт тохирсон ажлын байранд орж, тогтвортой ажиллахад туслан дэмжинэ.

4.2.3. аймаг, нийслэлийн хэмжээнд нэгдсэн зар мэдээ, сүлжээ, цахим хуудас бий болгох, сурталчилгаа, өдөрлөг зохион байгуулж болно.

4.2.4. иргэдийг цагийн ажилд бүртгэх, ажилд зуучлах, мэдээллийн сан үүсгэх үйлчилгээг хөдөлмөрийн бирж, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага болон албан ёсны зуучлагч байгууллагын хамтын ажиллагаанд тулгуурлан зохион байгуулна. Цагийн ажлын хөлсийг цагийн ажлын жишиг зардлаар тооцон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

4.3. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний нэгдсэн бүртгэл, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах

4.3.1.ажил хайх, ажил олоход туслалцаа үзүүлэхэд чиглэсэн тодорхой ажил мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээлэл цуглуулах, боловсруулах, ажил мэргэжлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, мэдээллийн нэгдсэн сангийн боловсруулсан мэдээллийг ажил хайгч иргэнд хүргэх, олон нийтэд хөдөлмөр

---

[5] Бүлгийн зөвлөгөөний 10 хувь нь үйлдвэрлэлийн дадлага байж болно.

[6]Туршилтын төслийн ("Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэх төсөл") хүрээнд сонгогдсон аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний зөвлөхийн холбогдох санхүүжилтийг хуваарилна. Зөвлөх тухайн аймаг, дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагатай гэрээ байгуулна. Зөвлөхийн урамшууллын хэмжээ болон бусад нөхцөлүүдийг Туршилтын төслийн багийн тооцоолол, судалгаанд үндэслэн зөвлөхтэй байгуулах гэрээнд тусган хэрэгжүүлнэ.

эрхлэлтийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах суурь үйлчилгээг үзүүлнэ.

4.3.2.аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн бирж нь иргэд болон ажил олгогчид хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээг олон нийтэд зориулсан арга хэмжээний үеэр, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр, мэдээллийн самбар, хэвлэмэл материал зэрэг (ном, лавлагаа, мэдээллийн эмхэтгэл, товхимол, сэтгүүл) хэлбэрээр үзүүлж болно.

ТАВ. ХӨДӨЛМӨРТ БЭЛТГЭХ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан төсөл, хөтөлбөр, бүтээн байгуулалтын хэрэгцээ шаардлага, тусгайлан баталсан хөтөлбөр[7], "Цагаан алт" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх зорилт, хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан тухайн орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн захиалга, шаардлагад нийцсэн мэргэжлийн ур чадварыг иргэнд богино хугацаанд олгох, давтан сургах, мэргэшүүлэхэд болон хувиараа хөдөлмөр эрхлэх мэдлэгийг олгох замаар хөдөлмөрийн зах зээлд нэвтрүүлэхэд энэхүү үйл ажиллагааны зорилго оршино.

5.1. Сургалт нь дараах төрөл, хэлбэрээр хэрэгжинэ:

5.1.1. суурь ур чадварын сургалт;
5.1.2. танхимын мэргэжлийн сургалт;
5.1.3. ур чадварын цахим сургалт;
5.1.4. ажлын байран дээрх мэргэжлийн сургалт (онол, дадлагын хосолмол);
5.1.5. бизнес санаа хөгжүүлэх, төсөл боловсруулах сургалт;
5.1.6. бизнес эрхлэх ур чадварын сургалт.

5.2.Хөдөлмөрт бэлтгэх хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

5.2.1. хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгээс тодорхойлсон эрэлттэй 20 хүртэл мэргэжлийн чиглэлээр сургалт зохион байгуулж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллана.

5.2.2. аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь эрх бүхий байгууллагаар сургалтын хөтөлбөрийн дүгнэлт гаргаж батлуулсан Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд заасан эрх бүхий байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлнэ.

5.2.3. гэрээлэн гүйцэтгэх эрх бүхий байгууллага нь танхимын, ажлын байран дээрх болон цахим сургалтыг чадамжид суурилсан хөтөлбөрөөр зохион байгуулж, чадамжийн гэрчилгээ олгоно.

5.2.4. хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг[8] холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн энэхүү хөтөлбөрийн болон Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөрт заасан зарим агуулга, төрөл, хэлбэрийг ашиглан зохион байгуулж болно.

---

[7]Энэхүү хөтөлбөрийн 9.1.1, 9.1.3-д заасан хөтөлбөрүүд.

[8]Тухайн орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага мэргэжлийн боловсрол сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвийн чадавх нөөцөөс хамааран хөдөлмөрт бэлтгэх сургалтад хуваарилсан хөрөнгийн 15 хүртлэх хувийг хамтран зохион байгуулж болно.

5.2.5. хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдах иргэдийг мэдээллээр хангах, бүртгэх, зохион байгуулах асуудлыг аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага хариуцаж ажиллана.

5.2.6. аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага болон сургалтын байгууллага нь сургалтад хамрагдсан иргэдийг ажилд зуучлах ажлыг хамтран зохион байгуулна.

5.2.7. хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь эрх бүхий сургалтын байгууллагын (хөтөлбөрт дүгнэлт гаргуулсан) мэдээллийг ил тод, нээлттэй мэдээлнэ.

5.2.8. сургалтын үр нөлөөний үнэлгээг Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн хариуцан зохион байгуулж, хяналт тавина.

5.3. Суурь ур чадварын сургалт

5.3.1. Суурь ур чадварын сургалт нь ажлын байр дахь зөөлөн ур чадвар, хөдөлмөрийн бүтээмж, сэтгэл зүйн эрүүл мэнд, цахим хэрэглээний мэдлэг, хөдөлмөрийн харилцааны суурь ойлголтууд, ажилтан, ажил олгогчийн эрх, үүрэг, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн анхан шатны мэдлэг олгох агуулгатай байна.

5.3.2. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь

- сургалтад хамрагдсан иргэдийг өөрийн үнэлгээгээр сургалтын өмнөх болон дараах ур чадварыг тодорхойлж, улирлаар захиргааны тоон мэдээллийн тайлан бэлтгэнэ. (3-ХЭДХ-1В маягтын дагуу)
- сургалтад хамрагдсан иргэдийг ур чадварын тодорхойлолтод үндэслэн дараагийн шатны дэмжлэгт хамруулна.
- нийгмийн халамжийн асуудал хариуцсан нэгж, албан хаагчдын оролцоог хангаж, харилцан уялдаатайгаар хамтран зохион байгуулна.

5.4. Чадамжид суурилсан мэргэжлийн сургалт

5.4.1. Танхимын мэргэжлийн сургалт

a.Танхимын мэргэжлийн сургалтыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай болон бусад хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах ба сонгон шалгаруулалтыг холбогдох үйл ажиллагааны зардлаас санхүүжүүлж болно.

b.Энэхүү хөтөлбөрийн 9.1.4-т заасан хөтөлбөрийн хүрээнд аймгийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь тухайн орон нутгийн цэргийн анги, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагатай хамтран Батлан хамгаалахын, Боловсролын болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтран баталсан 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/30-А/12-А/04 тоот журмын дагуу хугацаат цэргийн албан хаагчдыг сургалтад хамруулна.

5.4.2. Ажлын байр дээрх мэргэжлийн сургалт

a. ажил олгогчийн захиалгаар, ажил олгогчийн шаардлагад нийцсэн ажилтныг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар дамжуулан, эрх бүхий байгууллагаас баталсан хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрлэлийн орчин, ажлын байран дээр дадлагажуулан сургах замаар ур чадвар олгох, ажлын байраар хангах хэлбэрээр сургалтыг зохион байгуулна.

b. ажил олгогч нь Хөдөлмөрийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд байх бөгөөд нийт ажилтны 50 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний ажилтанг ажлын байранд сургаж болно.

c. сургалт захиалсан аж ахуйн нэгж нийт дадлагажин суралцагчдын 80-аас доошгүй хувийг ажлын байраар хангана.

5.4.3. Цахим ур чадвар олгох богино хугацааны сургалт

Хүн амын бүлгүүдийн эрэлт хэрэгцээ, онцлогт нийцүүлэн ажил хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай цахим ур чадвар олгох сургалтыг Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтран зохион байгуулж болно.

5.5. Аж ахуй эрхлэлтийн сургалт[9]

5.5.1. Бизнес санаа хөгжүүлэх, төсөл бичих сургалт

Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь санхүүгийн дэмжлэг, жижиг зээл авахаар төлөвлөсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтэд үндэслэн бизнес санаа хөгжүүлэх, төсөл боловсруулах сургалтыг гэрээний дагуу зохион байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

5.5.2. Бизнес эрхлэх ур чадварын сургалт

a. бичил бизнес, үйлчилгээ эрхлэгч нарын бизнесийн үйл ажиллагааг тогтвортой явуулах, төслөө амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү сургалтыг зохион байгуулна.

b. гарааны бизнес, бичил бизнес, үйлчилгээ эрхлэгч нарыг бизнесээ өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх уулзалт, хэлэлцүүлэг, туршлага судлах арга хэмжээг жилд нэг удаа зохион байгуулна.

ЗУРГАА.САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ажлын байр бий болгох, хадгалах, бичил болон гарааны бизнесийг эхлүүлэх, эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх, сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөгдөх болон хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох, түүнчлэн бусад холбогдох дэмжлэг үзүүлэхэд уг үйл ажиллагааны зорилго оршино.

6.1. Тусгайлан баталсан хөтөлбөр[10]-т хамрагдсан иргэдийг санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд хамруулж болно.

6.2. Тусгайлан баталсан хөтөлбөрт хамрагдсан иргэдийн бизнесийн төсөл нь гарааны бизнес байж болно.

6.3. Тусгайлан баталсан хөтөлбөрт хамрагдсан иргэдэд 5.0 сая төгрөгөөс бага хэмжээний санхүүгийн дэмжлэгийг олгож болно.

6.4. Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг үйлдвэрлэл, үйлчилгээний тодорхой чиглэл харгалзахгүйгээр зохион байгуулах ба шаардлагатай бол ижил төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээг бүлгээр зохион байгуулж болно.

6.5. Санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл, хоршооноос ирүүлсэн бизнесийн төслийг сонгон шалгаруулах байдлаар зохион байгуулах ба сонгон шалгаруулалтын үе шат бүр нь ил тод, нээлттэй иргэд,

---

[9] Энэхүү хөтөлбөрийн 9.1.1, 9.1.2-д заасан хөтөлбөрүүд

[10] Энэхүү хөтөлбөрийн 9.1.1, 9.1.2-д заасан хөтөлбөрүүд

оролцогчдын оролцоог хангаж, шударга өрсөлдөх боломжийг бүрэн хангасан байна. Ажлын хэсэгт санхүү, бизнесийн чиглэлээр ажилладаг иргэн болон төрийн бус байгууллагын төлөөллийг заавал оруулна.

6.6. Санхүүгийн дэмжлэгт хамрагдах төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мөнгөн дүнг бууруулахгүй олгох зарчмыг баримтална.

6.7. Санхүүгийн дэмжлэг авахаар шалгарсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай тухайн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага гэрээ байгуулж, эргэн төлөлтийг хариуцан ажиллах ба эргэн төлөлтийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлнэ.

6.8. Бусад хөтөлбөр, төслийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэнд санхүүгийн дэмжлэгийг давхардуулан олгохгүй ба санхүүгийн дэмжлэг авсан иргэн[11]

6.9. гэрээнд заасан хугацаанд нийгмийн даатгалд заавал хамрагдана.

6.10. Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын бусаар, үр ашиггүй зарцуулсан тохиолдолд хугацаанаас өмнө 100 хувь буцаан төлүүлэх бөгөөд дахин хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хамрагдахгүй байх үндэслэл болно. Харин амжилттай хэрэгжүүлсэн тохиолдолд Засгийн газраас баталсан журмын дагуу шаталсан байдлаар санхүүгийн дэмжлэг олгож болно.

6.10.Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнд үзүүлэх санхүүгийн дэмжлэг

Сонгон шалгаруулалтад тэнцсэн аж ахуй, бичил бизнес үйлдвэрлэл, үйлчилгээ[12] эрхлэх хүсэлтэй иргэд, мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын төгсөгчдөд Засгийн газрын тогтоолоор баталсан журмын дагуу эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг олгоно.

6.11.Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг

6.11.1. нийслэлийн алслагдсан 3 дүүрэг, 21 аймгийн малгүй болон бог малд шилжүүлснээр 200 хүртэлх толгой малтай малчин өрхийг Засгийн газрын тогтоолоор баталсан журмын дагуу эргэн төлөгдөх нөхцөлтэй малжуулах санхүүгийн дэмжлэгт хамруулна.

6.11.2. санхүүгийн дэмжлэгийг мал худалдан авч өгснөөс хойш 36 сарын дотор хуваарийн дагуу 100 хувь буцаан мөнгөн хэлбэрээр төлнө. Малчин өрхийн өөрийн боломжид тулгуурлан боловсруулсан "Эргэн төлөлт хийх төлөвлөгөө"-г малчин өрх, хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны Засаг дарга нарын гурвалсан гэрээнд хавсаргана.

6.11.3. арга хэмжээнд хамрагдах малчин өрхийг сум, хорооны Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг үндэслэн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага сонгож, гэрээ байгуулан ажиллах бөгөөд гэрээнд эргэн төлөлтийн хуваарийг иргэний хүсэлтийг үндэслэн тогтоож, хавсаргана.

6.11.4. аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага мал худалдан авч өгөх үйл ажиллагааг хуулийн дагуу нээлттэй, ил тод зохион байгуулах бөгөөд худалдан авч байгаа малын үнэ зах зээлийн дундаж үнээс илүүгүй байна.

---

[11] Санхүүгийн дэмжлэгийн үйлчилгээнд хамрагдахаас өмнө Нийгмийн даатгалд хамрагдаагүй байж болно.

[12] "Үйлчилгээ" гэдэгт бэлэн бараа бүтээгдэхүүн худалдаалах үйл ажиллагаа хамааруулахгүй.

6.11.5. малжуулах санхүүгийн дэмжлэгт хамрагдсан малчин өрхөд зориулан дараах арга хэмжээг зохион байгуулна[13].

a. байгалийн гамшиг болон эрсдэлт нөхцөлд бэлэн байдлыг хангах, мал маллах арга ухааны болон малын ашиг шимийг нэмэгдүүлэх арга технологийн талаар сургалтын арга хэмжээнд хамруулна.

b. орон нутгийн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, хэрэглэгч болон борлуулалт, худалдааны сувагтай холбох замаар өрхийн үйлдвэрлэл, орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

c. мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, эрчимжсэн мал аж ахуйн туршлага солилцох арга хэмжээнд хамруулна. Үүнд Улаанбаатар хотын төвийн дүүргийн иргэд хамаарахгүй.

6.12.Гарааны бизнес эрхлэгч залуучуудыг дэмжих санхүүгийн дэмжлэг

6.12.1.дэвшилтэт шинэ технологи, инноваци бүхий шинэлэг санааг агуулсан, ногоон ажлын байр бий болгох, өндөр ур чадвар шаардах буюу технологийн ажлын байр бий болгох төслийг боловсруулсан шилдэг гарааны бизнес эрхлэгч 15-34 насны залуучуудын багийг нээлттэй өрсөлдөөний зарчмаар шалгаруулж, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгоно. Үүнд:

- улсын хэмжээнд 1 дүгээр байр-1 баг, 2 дугаар байр-2 баг, 3 дугаар байр- 3 баг,
- аймаг, нийслэлийн хэмжээнд 1 дүгээр байр-1 баг, 2 дугаар байр -1 баг, 3-р байр-1 баг тус тус байна.

6.12.2.улсын хэмжээний шилдэг "Старт-Ап" арга хэмжээг зохион байгуулахдаа гарааны бизнесийг дэмжсэн үйл ажиллагаа явуулдаг, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр, арга зүйтэй эрх бүхий байгууллагатай хамтарч болно.

6.12.3.улсын хэмжээний шилдэг "Старт-Ап" арга хэмжээнд оролцож, шалгарсан бизнес санаа, бизнесийг сурталчлах зорилгоор нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд түгээж болно.

6.12.4.шилдэг гарааны бизнес шалгаруулах уралдаанд оролцож байсан төсөл болон багийг дахин хамруулахгүй бөгөөд шалгаруулалтад оролцож буй төслүүдийг мэдээллийн нэгдсэн систем /ejob/-д бүртгэж, хадгална.

6.12.5.гарааны бизнесийн санааг боловсронгуй болгох, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг их, дээд сургууль, бизнесийн зөвлөх (ментор)-ийн оролцоотойгоор зохион байгуулж болно.

6.12.6.санхүүгийн дэмжлэгт хамрагдсан гарааны бизнес эрхлэгч залуучуудад мэдлэг туршлага хуваалцах, бизнесээ өргөжүүлэх боломж бүрдүүлэх, амжилттай хэрэгжиж буй бизнесийг нь сурталчлах зэргээр дэмжлэг үзүүлнэ.

6.13. Бага насны хүүхэд болон байнгын асаргаатай хүнийг асарч байгаа иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг

6.13.1. аж ахуй, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 0-8 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, эцэг болон байнгын асаргаатай хүн асарч байгаа иргэн[14]-д Засгийн газрын тогтоолоор баталсан журмын дагуу 24 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгоно.

---

[13]Энэхүү хөтөлбөрийн 9.1.1-д заасан хөтөлбөрийн хүрээнд.

[14]Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний өдрийн болон гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг иргэн байж болно.

6.13.2. аж ахуй, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй 0-8 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, эцэг болон байнгын асаргаатай хүн асарч байгаа иргэнийг бизнес инкубацын үйлчилгээнд хамруулж болно.

6.14. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг

Иргэнд олгох санхүүгийн дэмжлэгийн адил шаардлагын дагуу аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй ахмад настны төслийг сонгон шалгаруулж, тэнцсэн ахмад (өндөр насны, цэргийн, хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон хүн) настанд Засгийн газрын тогтоолоор баталсан журмын дагуу 36 хүртэл сарын хугацаатай эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг олгоно.

6.15.Мод тарих, ургуулах, арчлах арга хэмжээ[15]ний санхүүгийн дэмжлэг

6.15.1. Мод тарих, ургуулах, арчлах, орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн болон иргэдийн бүлэгт ажлын үр дүнд[16] тулгуурлан тэдний тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Засгийн газрын тогтоолоор баталсан журамд заасан хэмжээгээр 24 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийг олгоно[17].

6.15.2. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа нь иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээтэй адил байх ба бүсийн онцлог, цөлжилтөөс шалтгаалан аймаг, дүүрэг бүрт 2-3 төсөл шалгаруулна.

6.16.Ажил олгогчийг дэмжих

6.16.1. ажилгүй иргэнийг 12 сараас доошгүй хугацаагаар байнгын ажлын байраар хангаж, тогтвортой ажиллуулж байгаа улсын бүртгэлийн болон татвар, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй, аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл, хоршоонд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшуулал олгоно. Урамшууллыг тухайн байнгын ажилд орсон иргэн бүрээр тооцон тухай бүр олгоно.[18]

6.16.2. хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан (Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан) иргэнийг үйлдвэрлэл дээрээ дадлагажуулан үндсэн ажилтнаар нэг жилээс доошгүй хугацаагаар үргэлжлүүлэн байнгын ажлын байраар хангаж байгаа ажил олгогчид дадлагын хугацааны сургалтын зардлыг нөхөн олгож, нэг жилийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний санхүүгийн дэмжлэгийг бий болгосон байнгын ажлын байрны тоогоор нэг удаа олгоно.

6.16.3. энэхүү хөтөлбөрийн 6.16.1, 6.16.2-д заасан ажил олгогч нь ажлын байраар хангах тухайгаа өөрийн харьяалах аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад мэдэгдэн гэрээг байгуулах ба ажлын байраар хангасан иргэнийг нийгмийн даатгалд хамруулж, цалин хөлсийг олгосон тухай баримт бичгийг бүрдүүлнэ.

6.16.4. ажил олгогч нь гэр бүлийн гишүүн буюу ойрын хамаарал бүхий иргэнийг ажилд авсан тохиолдолд дэмжлэг олгохгүй.

6.17. Туршилтын төсөл, хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх.

---

[15]"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангахад болон байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ.

[16] Модны ургалт, модны тоо хэмжээ, ойжуулсан талбайн хэмжээний өсөлт зэргийг харгалзан үзнэ.

[17] Уг арга хэмжээнд иргэн ганцаарчлан болон бүлгээр/баг болох/ хамрагдаж болно.

[18] Ажлын байртай болсон иргэнийг тус урамшуулалд давтан хамруулахгүй.

Засгийн газрын болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр, төслийг оновчтой зохион байгуулах, бодит үр дүнд хүрэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Засгийн газрын 340 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх" журмын 5.17-д заасны дагуу 36 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй 30 хүртэлх сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг[19] нэг удаа олгож болно.

6.18. Түрээсийн дэмжлэг үзүүлэх

6.18.1. аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 6 болон түүнээс дээш сарын хугацаагаар ажлын байр түрээслэн үйл ажиллагаа явуулж байгаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсан, гэрээний хугацаа нь хүчинтэй байгаа иргэн, аж ахуйн нэгжид, түрээсийн гэрээ, холбогдох баримт бичиг, газар дээрх нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн тухайн жилийн 6 хүртэл сарын хугацааны түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг зах зээлийн үнэлгээтэй уялдуулан нягталж, төлбөр төлсөн баримтад үндэслэн, батлагдсан жишиг зардлаас хэтрүүлэхгүйгээр улиралд нэг удаа нөхөн олгоно.

6.18.2. ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгж тухайн иргэдийн ажлын байрыг хадгалах үүрэг хүлээх бөгөөд энэ тухайгаа зохион байгуулагч талтай байгуулах гэрээнд тусгана.

6.18.3. иргэн нь түрээсийн төлбөрийн хөнгөлөлтөд үйлдвэрлэлийн, эсхүл үйлчилгээний аль нэг чиглэлээр хамрагдана. Үйлчилгээний төрөлд хүнсний болон бэлэн бараа бүтээгдэхүүн худалдан борлуулах үйл ажиллагаа хамаарахгүй болно.

6.18.4. ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор орон нутгийн ахмадын төвийг энэхүү дэмжлэгт хамруулж болно.

6.19.Борлуулалтын дэмжлэг үзүүлэх

6.19.1. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн болон бусад дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжих зорилгоор орон нутагт борлуулалтын цэг ажиллуулж, төрөлжсөн худалдааны цахим хуудастай хамтарч ажиллана.

6.19.2. борлуулалтын цэгийг ажиллуулах зардлыг зөвхөн түрээсийн төлбөр болон урсгал зардал (цахилгаан, дулаан, интернэт гэх мэт)-д зарцуулна. Борлуулалтын цэг дээр ажиллах борлуулагчид цалин, урамшуулал олгохгүй буюу борлуулалтын цэгт хамрагдаж байгаа иргэдийг тодорхой хуваарийн дагуу ажиллуулах, эсхүл иргэдтэй харилцан тохиролцож, борлуулалтын орлогын тодорхой хувиар цалин, урамшууллыг олгох байдлаар зохион байгуулна.

6.19.3. борлуулалтын цэгийг бизнес инкубатор төвтэй гэрээлэн ажиллуулж болох бөгөөд энэ тохиолдолд санхүүжилтийг "Борлуулалтын цэг ажиллуулахад зарцуулах нэг сарын зардлын дээд хэмжээ"-ээс хэтрүүлэхгүй.

6.19.4. борлуулалтын цэг нь бараа, бүтээгдэхүүн борлуулахад дэмжлэг үзүүлж, борлуулалтын захиалга хүлээн авах, сурталчлах, худалдан авагчидтай холбох зэрэг арга хэмжээг зохион байгуулна.

---

[19]Шинээр байгуулагдах "Job center" төвийн 1 биржид 15 хүртэлх сая төгрөг, нэг "Job center" төвд 30 хүртэлх сая төгрөг байна.

6.19.5. малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчин өрхийг орон нутгийн сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, хэрэглэгч болон борлуулалт, худалдааны сувагтай холбох замаар өрхийн үйлдвэрлэл, орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

6.19.6. аймаг, дүүргийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд жилд 3-аас илүүгүй удаа үзэсгэлэн худалдаа зохион байгуулж болно.

ДОЛОО. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөр эрхлэх, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх, тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн тохируулгатай ажлын байр бий болгох, ажил олгогчийг дэмжихэд чиглэсэн үйлчилгээ, арга хэмжээ (дохионы хэлмэрч, ажлын байрны тохируулга г.м)-г хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

7.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээ[20] (Job Coaching)

7.1.1. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамрагдах иргэнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын баталсан аргачлал, удирдамжийн дагуу цогц үнэлгээг хийж, тухайн үнэлгээнд үндэслэн, зөвлөгөө өгч, хувийн төлөвлөгөө боловсруулж, тохирох арга хэмжээнд хамруулна.

7.1.2. Улаанбаатар хотод туршилтаар хэрэгжүүлж буй "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээ" нь дараах багц төрөлтэй байна. Үүнд:

- Сэтгэлзүйн;
- Зан үйлийн;
- Эрүүл мэндийн;
- Хөдөлгөөнт үйлийн;
- Хөдөлмөрлөх ур чадварын.

7.1.3. үнэлгээнд үндэслэн хөдөлмөр эрхлэх хүсэлтэй иргэнийг хувийн туслахын үйлчилгээнд хамруулж болох бөгөөд үйлчилгээний хөлсийг ажил, хөдөлмөр эрхлэх болсон эхний 3 сарын хугацаанд нийт 120 цагаас хэтрүүлэхгүйгээр тооцож батлагдсан жишиг үнийн дагуу үйлчилгээг үзүүлсэн байгууллагад гэрээний дагуу олгоно.

7.1.4. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээний хүрээнд дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

a. хувь хүн, гэр бүлд харилцаа хандлага, сэтгэл заслын сургалт хийх, зөвлөгөө мэдээлэл өгөх, гэрээ байгуулах;

b. үнэлгээнд үндэслэн хувийн төлөвлөгөө боловсруулах;

c. ахуйн дэмжлэг үзүүлэх буюу хөдөлмөр эрхлэхэд тулгарч буй бэрхшээл, саадыг арилгах зорилгоор төрийн бусад үйлчилгээнд хамруулах, зуучлах, чиглүүлэх;

d. зорилтот ажлын байр буюу халамжийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах;

e. хөдөлмөрийн нөхөн сэргээлтийн үйлчилгээнд хамруулах;

---

[20]Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв нь 2025 онд хэрэгжүүлж эхэлсэн арга хэмжээг 2026 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

f. ажил, хөдөлмөр эрхлэх боломжтой хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөрийн нээлттэй зах зээл дээр ажиллахад дэмжлэг үзүүлэх;

g. бизнес инкубацын үйлчилгээгээр дамжуулан хувиараа бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

7.1.5. хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээнд хамрагдаж буй хүн бүрт энэхүү хөтөлбөрийн 7.1.4.a, 7.1.4.b-д заасан үйлчилгээг үзүүлнэ.

7.1.6. иргэний үнэлгээ болон хувийн төлөвлөгөөнд үндэслэн энэ хөтөлбөрийн 7.1.4.c-д заасан үйлчилгээнд хамруулахгүй байж болох ба 7.1.4.d-g-д заасан үйлчилгээг сонголтоор үзүүлнэ.

7.1.7. иргэн энэхүү хөтөлбөрийн 7.1.4.d-e-д заасан үйлчилгээнд хамрагдаж дуусаад 7.1.4.f болон 7.1.4.g-д заасан үйлчилгээнд шатлан хамрагдаж болно.

7.1.8. цогц арга хэмжээг бэрхшээлийн төрлөөр хуваж зохион байгуулах ба арга хэмжээ бүрийн үргэлжлэх хугацаа 10 сар байна.

7.1.9. цогц арга хэмжээний үйлчилгээнд 1 жилийн дотор давхардуулан хамруулахгүй. Арга хэмжээнд хамрагдах хугацааг дуусгасны дараа үнэлгээнд үндэслэн дахин хамрагдах эсхүл өөр арга хэмжээнд шатлан хамрагдаж болно.

7.1.10. нэг бизнес инкубатор төв нь 10 бойжигчтой байх ба шаардлага хангасан мэргэшсэн байгууллагыг сонгон шалгаруулах байдлаар энэхүү үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлнэ.

7.1.11. хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээг шаардлага хангасан, чадавх бүхий төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж болох ба санхүүжилтийг сар бүрийн гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулан олгоно.

7.2. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ

Санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээг энэхүү үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1-6.9-д заасны дагуу зохион байгуулна[21].

7.2.1. Иргэнд үзүүлэх санхүүгийн дэмжлэг

Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ, өрхийн аж ахуй эрхэлж, ажлын байр бий болгох зорилготой хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа (давхар хөдөлмөр эрхэлдэггүй) хүний боловсруулсан төслийг шалгаруулж, Засгийн газраас тогтоосон хэмжээгээр барьцаагүй, хүүгүй, санхүүгийн дэмжлэгийг 36 хүртэл сарын хугацаанд 50 хувийг нь эргэн төлөх нөхцөлтэй олгоно.

7.2.2. Аж ахуйн нэгжид үзүүлэх санхүүгийн дэмжлэг

Хөгжлийн бэрхшээлтэй хүний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгжийн бизнесээ өргөжүүлэх, ажлын байрны тохируулга хийх, технологио шинэчлэх, шинээр бий болгосон ажлын байраа хадгалах, шинээр тохируулгатай ажлын байр бий болгож хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тогтвортой ажиллуулах тухай төсөлд Засгийн газрын тогтоосон хэмжээгээр, барьцаагүй, хүүгүй, 36 хүртэл сарын хугацаатай санхүүгийн дэмжлэгийг, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид Засгийн газраас тогтоосон

[21] Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүн болон түүний үүсгэн байгуулсан ААНБ нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах, ажлын байр шинээр бий болгох үүрэг хүлээхгүй байж болно.

хэмжээгээр 48 хүртэл сарын хугацаатай санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөх нөхцөлтэйгөөр тус тус олгоно.

7.3. Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг

7.3.1. үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ажлын байр түрээслэн 6 сараас дээш хугацаагаар тасралтгүй үйл ажиллагаа эрхэлсэн хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй хүн, мөн нийт ажилтны 50-иас доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй аж ахуйн нэгж, байгууллага, хөгжлийн бэрхшээлтэй хүний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, бизнес инкубатор төвийн бойжигчид гэрээний хүчинтэй хугацаагаар тооцон тухайн жилийн 6 хүртэл сарын хугацаанд түрээсийн төлбөрийн дэмжлэгийг олгоно.

7.3.2. хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь ажлын байрыг дангаар болон хамтран түрээсэлж болох бөгөөд энэ тохиолдолд нотлох баримтад үндэслэн шаардлага хангасан түрээслэгч бүрт түрээсийн дэмжлэгийг баталсан жишиг үнийн дагуу олгоно.

7.3.3. Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3 дахь хэсгийг хэрэгжүүлэх журмын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүний борлуулалтын дэмжлэгийг үзэсгэлэн зохион байгуулах[22], нэг удаагийн борлуулалт хийхэд холбон зуучлах, байнгын борлуулалтын сувгийг сонгоход дэмжлэг үзүүлэх хэлбэрээр хэрэгжүүлнэ.[23]

7.3.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь Олон Улсын болон Монгол Улсын хэмжээнд зохион байгуулагдах үзэсгэлэнг урьдчилан судалж хамрах хүрээ, ач холбогдол, үр дүнг үндэслэн сонгож, 2027 онд хэрэгжих хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний төсөлд санал боловсруулан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

7.3.5. хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага үзэсгэлэнд оролцох хувь хүн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагын үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн нь Олон Улсын болон дотоодын зах зээлд өрсөлдөхүйц чанартай, өнгө үзэмжтэй, шинэлэг, инноваци шингэсэн эсэхийг харгалзан сонгон шалгаруулах байдлаар зохион байгуулах бөгөөд сонгон шалгаруулалтаар шаардлага хангахуйц бараа, бүтээгдэхүүн байхгүй тохиолдолд гадаадад зохион байгуулагдах үзэсгэлэнд оролцохгүй. Түүнчлэн үзэсгэлэнгээр дамжуулан бизнес эрхлэгч, хувь хүнтэй байгуулсан хамтын ажиллагааны гэрээний тоо, борлуулалтын үнийн дүнгээр үр дүнг тооцно.

7.3.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар нь хөгжлийн бэрхшээлтэй хүний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, худалдан борлуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор жилд нэг удаа өөрсдийн санаачилгаар Монгол Улсын хэмжээнд үзэсгэлэн зохион байгуулж болно.

7.3.7. борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйлчилгээг гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх хэлбэрээр зохион байгуулах бөгөөд нэг удаагийн борлуулалтад зуучилсан тохиолдолд нийт борлуулалтын үнийн дүнгийн 10%-ийг тухай бүр, байнгын буюу 12 сараас дээш хугацаагаар худалдан борлуулах сувагт зуучилсан тохиолдолд нийт үнийн дүнгийн 20%-ийг гэрээ дуусганы дараа нотлох баримтад үндэслэн зуучлагчид урамшуулал болгон тус тус олгоно.

7.3.8. үзэсгэлэн худалдаагаар дамжуулан борлуулсан бүтээгдэхүүний ашиг нь үзэсгэлэн худалдаанд зарцуулсан зардлын зөрүүнээс илүү гарсан дүнгээс энэхүү хөтөлбөрийн 7.4.7-д заасан урамшууллыг олгоно.

---

[22] Батлагдсан төсвийн 40 хувиас хэтрүүлэхгүй.

[23] Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга удирдлага, зохион байгуулалтаар хангана.

7.3.9. энэхүү хөтөлбөрийн 7.4.7-д заасан борлуулалтын дэмжлэгийн үйлчилгээ үзүүлэх зуучлагч нь худалдах, худалдан авах, хамтран ажиллах 2 талын хамаарал бүхий этгээд, 2 талын ажилтан албан хаагч, эсхүл төрийн албан хаагч байж болохгүй.

7.3.10. энэхүү хөтөлбөрийн 7.4.7-д заасан арга хэмжээг зохион байгуулах байгууллага нь зуучлагчийн хүсэлтийг урьдчилан хүлээн авч бүртгэлжүүлэн мэдээллийн сан үүсгэж, гэрээ байгуулна.

7.3.11. зуучлагчаар дамжуулан борлуулалтын дэмжлэгт хамрагдах хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж нь бараа бүтээгдэхүүний жагсаалт, тайлбар, тоо хэмжээ, үйлдвэрлэх хүчин чадал гэх мэт мэдээллийг зохион байгуулагчид ирүүлэн мэдээллийн санд бүртгүүлж, гэрээ байгуулна.

7.3.12. зохион байгуулагч тал зөвхөн мэдээллийн санд орсон, бүртгэл нь баталгаажсан бараа бүтээгдэхүүнийг гэрээ байгуулсан бүртгэлтэй зуучлагчаар дамжуулан борлуулах ажлыг зохион байгуулна.

7.3.13. зуучлагч нь бүртгэлтэй бараа, бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, сайжруулах, сурталчлах ажлыг үйлдвэрлэгч талтай зөвшилцөн хийж болох бөгөөд энэхүү ажилтай холбогдон гарах зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэхгүй.

7.3.14. борлуулалтын цэгийг ажиллуулах зардлыг зөвхөн түрээсийн төлбөр болон урсгал зардал (цахилгаан, дулаан, интернэт гэх мэт)-д зарцуулна. Борлуулалтын цэг дээр ажиллах борлуулагчид цалин, урамшуулал олгохгүй буюу борлуулалтын цэгт хамрагдаж байгаа зорилтот бүлгийн иргэдийг тодорхой хуваарийн дагуу ажиллуулах, эсхүл зорилтот бүлгийн иргэдтэй харилцан тохиролцож, борлуулалтын орлогын тодорхой хувиар цалин, урамшууллыг олгох байдлаар зохион байгуулна.

7.3.15. борлуулалтын цэгийг бизнес инкубатор төвөөр гэрээлэн ажиллуулж болох бөгөөд энэ тохиолдолд санхүүжилтийг "Борлуулалтын цэг ажиллуулахад зарцуулах нэг сарын зардлын дээд хэмжээ"-ээс хэтрүүлэхгүйгээр олгоно.

7.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ажлын байр бий болгосон ажил олгогчид үзүүлэх дэмжлэг

7.4.1. хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар тогтвортой ажиллуулж, цалин хөлс олгож, нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн ажил олгогч, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагад байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй ажилтны тоогоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг нэг удаа олгоно.

7.4.2. хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тогтоосон хувиас илүү хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авч, 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан бол хуулиар тогтоосон хувиас илүү гарсан байнгын ажлын байраар хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүний тоогоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшууллыг[24] нэг иргэнийг нэг удаа үндэслэн олгох бөгөөд хуульд заасан шаардлага хангасан иргэн бүрийн тоогоор олгоно.

7.4.3. хөдөлмөр эрхлэлтийн байгууллагууд нь дээрх гэрээний хэрэгжилт, хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж байгаа байнгын ажлын байрны тогтвортой байдалд тогтмол хяналт тавина.

---

[24]Урамшууллыг олгохдоо тухайн онд харгалзах байдлаар тооцож, өмнөх жилийн ажиллаж байсан хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоог хасаж тооцно.

7.5. Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаа

7.5.1 аж ахуй эрхлэлтийн сургалт[25]

a. санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгж байгууллага, санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд шалгарсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад шаардлагатай тохиолдолд сургалтыг зохион байгуулна.

b. санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийг бизнесээ өргөтгөхөд зориулсан уулзалт, хэлэлцүүлэг, туршлага судлах арга хэмжээг жилд 1 удаа зохион байгуулна.

7.5.2. чадамжид суурилсан мэргэжлийн сургалт

a. хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн А/310, А/130 дугаар хамтарсан тушаалаар баталсан "мэргэжлийн сургалтын байгууллагад тавих шаардлага"-ыг хангасан, тохируулгатай сургалтын орчин бүрдүүлсэн сургалтын байгууллагатай батлагдсан хөтөлбөрийн дагуу гэрээлэн гүйцэтгүүлэх бөгөөд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

b. хөгжлийн бэрхшээлтэй хүний хүсэл сонирхол, мэргэжил, ур чадварт нь тохирсон мэргэжлийн чадамж эзэмшүүлэх танхимын болон үйлдвэрлэл дээрх хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг сонгон зохион байгуулна.

c. сургалтын арга хэмжээний хүрээнд хөтөч, дохионы хэлмэрч бэлтгэх болон дохионы хэл заах, хараагүй хүмүүсийн орон зайн чиг баримжаа олгох сургалтыг хийж болох ба анхан шатны нэг удаагийн сургалтын үргэлжлэх хугацаа нь ажлын 5-аас доошгүй хоног байна.

7.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаа

7.6.1.ахуйн нэгж байгууллагуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйл хэрэгжилт болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулахад шаардлагатай мэдлэг ойлголтыг өгөх, мэргэжил аргазүйн зөвлөгөөг үзүүлэх зөвлөн туслах үйлчилгээний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана.

- мэргэшсэн зөвлөх бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулж, батлуулах;
- мэргэшсэн зөвлөхийн ажиллах дүрмийг боловсруулж, батлуулах;
- эрх бүхий мэргэшсэн зөвлөх бэлдэх сургалт зохион байгуулж, эрх олгох;
- мэргэшсэн зөвлөхтэй гэрээ байгуулж, ААНБ-уудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах. /Нийслэл болон 10 аймагт/

7.6.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бөгөөд ингэхдээ Засгийн газрын 2023 оны 402 дугаар тогтоолоор баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн ажиллах журмын 3.5-д заасан хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй.

---

[25]Энэхүү хөтөлбөрийн 9.1.1-д заасан хөтөлбөрт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөтөлбөрийн 5.6-д заасан арга хэмжээний хүрээнд хамруулна.

7.6.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх сайн жишээг түгээн дэлгэрүүлэх сурталчилгаа, нөлөөллийн ажлын хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулна.

- "Бэрх биш ээлтэй аян" арга хэмжээ /Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрлөх болон бусад эрхийг хамгаалах "олон улсын тэмдэглэлт өдөр"-үүдийг угтсан арга хэмжээг зохион байгуулах /аутизм, сонсгол, хараа, даун гэх мэт/;
- хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг шалгаруулах үйл ажиллагаа;
- хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдрийг угтсан арга хэмжээ /Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн хамт/;
- ABILITY EXPO-2026 арга хэмжээ /Дэд болон салбар зөвлөлтэй хамтран/;

7.6.5.хөдөлмөр эрхлэх боломжтой хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөдөлмөр эрхлэхэд зориулж хувийн туслахын арга хэмжээг хэрэгжүүлэх. Үүнд:

- хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилдаа ирж, очиход нь дэмжлэг үзүүлэх хувийн туслахын үйлчилгээ[26];
- хувийн туслах ажилтан бэлтгэх сургалтын үйлчилгээ.

7.6.6.хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- үндсэн системийг хөгжүүлэх;
- системийн хөгжүүлэлт дуусанаас хойш 1 жилийн засвар үйлчилгээ хийх, сайжруулах;
- гарын авлага, систем ашиглалтын журам боловсруулж, батлуулах;
- ажил олгогч, ТББ-ууд, олон нийтэд мэдээлэл өгөх, сурталчлан таниулах.

7.6.7.хөдөлмөр эрхэлж буй сонсголын бэрхшээлтэй хүнд зайнаас зөвлөн туслах, уулзалт хэлэлцүүлэг, дүрс бичлэгт дохионы хэлмэрчийн үйлчилгээг хувь хүн, байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлнэ.

7.6.8. дэлхийн ур чадварын Абилимп олон улсын тэмцээнийг үндэсний хэмжээнд зохион байгуулах, бэлтгэл хангахад дэмжлэг үзүүлнэ.

7.6.9.төрийн бус байгууллагуудын хүний нөөцийг чадавхжуулах, туршлага солилцох арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- хувийн туслах, Peer counseling чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Төрийн бус байгууллагуудын хүний нөөцийн чадавхад үнэлгээ хийх арга, аргачлал боловсруулах, чадавхжуулах сургалт хийх;
- чадавхжуулах сургалтын модуль, хөтөлбөр, гарын авлага боловсруулах;
- цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж буй 30 төрийн бус байгууллагуудын ажилтан албан хаагчдад энэхүү хөтөлбөрийн 7.1-д заасан арга хэмжээ, үйлчилгээг үзүүлэх онолын болон практик мэдлэг, ур чадвар эзэмшүүлэхэд чиглэсэн чадавхжуулах сургалт, арга хэмжээ.

7.6.10. хөгжлийн бэрхшээлтэй хүний ажлын байрны хүртээмжийн үнэлгээний арга хэмжээг хэрэгжүүлэх. Үүнд:

- мэргэшсэн зөвлөхийн ажиллах дүрмийг боловсруулж, батлуулах;
- мэргэшсэн зөвлөх бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулж, батлуулах;
- хүртээмжийн үнэлгээний мэргэшсэн зөвлөх бэлтгэх сургалт зохион байгуулж, эрх олгох;

---

[26]Долоо хоногт ажлын 5 өдрөөс, өдөрт 3 цагаас илүүгүй байна.

- мэргэшсэн зөвлөхтэй гэрээ байгуулж, ААНБ-уудад хүртээмжийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах.[27]

НАЙМ.ТҮР АЖЛЫН БАЙРААР ХАНГАХ БОЛОН АХМАД НАСТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, амьдарч буй орчны нийтийн эзэмшлийн зам, талбайг сайжруулах чиглэлээр ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн болон эзэмшсэн мэдлэг, туршлагадаа үндэслэн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөр эрхлэх хүсэлтэй ахмад настныг түр ажлын байраар хангах замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

8.1. Мод тарих, ургуулах, арчлах арга хэмжээ[28]

8.1.1."Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих, ахмад настны оролцоог хангах, тэдний орлогыг нэмэгдүүлэх зорилгоор мод тарих, услах, арчлах, орчныг хамгаалах арга хэмжээг зохион байгуулна.

8.1.2. хөтөлбөрийн 8.1.1-д заасан арга хэмжээг нийтийн эзэмшлийн зам, талбай, өөрийн эзэмшлийн хашаанд мод тарьж, ургуулж, тарьсан модыг арчлах байдлаар хэрэгжүүлж болно.

8.2. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ[29]

8.2.1. ахмад мэргэжилтний хөдөлмөрийн зах зээлд оролцох оролцоог нэмэгдүүлэх, орлогыг сайжруулах, эзэмшсэн мэдлэг, ур чадвар, ажлын туршлагыг залуу үеийнхэнд өвлүүлэх, зөвлөх үйлчилгээг сургалт, менторшип, дадлагын хэлбэрээр хэрэгжүүлнэ.

8.2.2. ахмад мэргэжилтний мэдээллийн сан бүрдүүлж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, дэмжлэгийн хэлбэрийг тогтоож, аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран зөвлөх үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.

8.2.3. ахмад мэргэжилтнийг эрүүл мэнд, боловсрол, аялал жуулчлал болон бусад салбарын улирлын шинжтэй ажлын байранд холбон зуучлан ажиллуулахад дэмжлэг үзүүлнэ.

8.2.4. мэргэжлийн шинжлэх ухаан, техникийн, санхүү болон даатгал зэрэг салбаруудын өндөр ур чадвартай, туршлагатай ахмад ажилтан болон өндөр насны тэтгэвэрт гарсан иргэнийг бичил, жижиг аж ахуйн нэгж, байгууллага, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан иргэн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийг чадавхжуулах сургагч багш, менторoор ажилууллах, зөвлөн туслах үйлчилгээг зохион байгуулж болно.

8.2.5. энэхүү хөтөлбөрийн 9.1.1-т заасан "Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд сонгогдсон өрхийг хөгжүүлэх, дадлагажуулах ахмадын зөвлөх үйлчилгээг тусгайлан хэрэгжүүлнэ.

---

[27]Улаанбаатар хотод болон 7 аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвд.

[28]"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангахад болон байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ.

[29]Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар "Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдах зөвлөхүүдийн мэдээллийн нэгдсэн сан"-г үүсгэж, хяналт тавьж ажиллана.

8.3. Ахмадын холбоо, төрийн бус байгууллагын зөвлөх үйлчилгээ[30]

8.3.1. орон нутгийн ахмад настны эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ зохион байгуулна.

8.3.2. ахмадын холбоо, төрийн бус байгууллага нь орон нутгийн ахмадын хөдөлмөр эрхлэлт болон нийтлэг эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажилласан туршлагатай, мэргэжлийн ур чадвартай баг, бүрэлдэхүүнтэй байх бөгөөд зөвлөх үйлчилгээний хүрээнд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, үйлчилгээ үзүүлнэ.

8.3.3. салбар бүрийн мэргэжлийн өндөр ур чадвар, мэдлэг, туршлагатай, хөдөлмөр зүтгэлээ төрд үнэлүүлсэн ахмад настнуудын холбоо, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээний үндсэн дээр салбарын залуу ажилтнууд, дадлагажигчид, оюутан суралцагчдад зөвлөгөө өгөх, зөвлөн туслах, туршлага хуваалцах, байгууллагуудтай хамтран сургалт, зөвлөгөөн зохион байгуулж болно.

8.4. Хүүхдийн эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээ

Аймаг, дүүргийн Цагдаагийн газар, хэлтэс болон Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газар, хэлтэс нь ахмад настныг[31]сонгон авч, холбогдох сургалтад хамруулах, хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчтай хамтран ажиллах, мэдээллээр хангаж, гэрээ байгуулан хүүхэд эрсдэлд өртөж болзошгүй орчинд хүүхдийг эрхийг хамгаалах чиглэлээр ажиллуулна.

ЕС. ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОДОРХОЙЛСОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын Засгийн газрын бодлого, хөтөлбөртэй уялдуулан тухайн жилийн онцлогт тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Мөн хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлэхээр тодорхойлсон хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилготой арга хэмжээ, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлнэ.

9.1.Засгийн газар болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрийн дагуу хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх үйлчилгээ, арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд тусгайлан боловсруулж, батлагдсан журамд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

9.1.1. “Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

9.1.2. "Цагаан алт” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд салбар хоорондын уялдааг хангах замаар энэхүү үйл ажиллагааны 4, 5.4, 5.5, 6.10, 6.18, 6.19-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх;

9.1.3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

9.1.4. “Хугацаат цэргийн алба хаагчдад мэргэжил эзэмшүүлэх сургалт”-ыг зохион байгуулах;

---

[30]Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар улсын хэмжээнд сонгон шалгаруулж, гэрээ байгуулж ажиллана.

[31]Боловсролын байгууллага, хүүхдийн байгууллага, цэрэг, цагдаагийн байгууллага, эрүүл мэндийн байгууллага болон бусад төрийн байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан иргэн байна.

9.1.5. 2026 онд 4 аймагт үйл ажиллагаа явуулах Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

9.1.6. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг ажил олгогчид дагалдуулан суралцуулахад дэмжлэг үзүүлэх;[32]

9.1.7. хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээг[33] үзүүлэх.

9.2. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор дараах үйл ажиллгааг хэрэгжүүлнэ.

9.2.1. Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн хэрэгжилтийг хангах;

9.2.2. Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, мэдээллийн системийг сайжруулах, шинэчлэх;

- гадаад ажилтны хөдөлмөр эрхлэхтэй холбоотой зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахимжуулах;
- хөдөлмөр эрхлэлтийн цахим систем И-жоб платформыг хөгжүүлэх;
- хөдөлмөр эрхлэлтийн цахим систем И-жоб платформын сүлжээний тоног төхөөрөмжийг шинэчлэх, лиценз сунгах;
- "Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх" хөтөлбөрийн мэдээллийн системийг хөгжүүлж, лиценз сунгах.

9.2.3. Хөдөлмөрийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхжуулах сургалт зохион байгуулах;

9.2.4. Хөдөлмөр эрхлэлтийг сурталчлах, олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ, хөдөлмөрийн яармаг, өдөрлөг зохион байгуулах, контент бэлтгэх, хууль тогтоомжийн хэлэлцүүлэг, зөвлөлгөөн зохион байгуулах;

- Хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөрийн мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах;
- Зохистой, тогтвортой, бүтээмжтэй хөдөлмөр эрхлэлтийн нөлөөллийн ажлыг хийх;
- Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн нөлөөллийн ажлыг хийх;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх аян, нөлөөллийн ажлыг хийх;
- Хүний нөөцийн сайн бодлого, туршлагыг сурталчлах, түгээх;
- Хүн амын бүлгүүдэд зориулан цахим ур чадварын хөгжил, хэрэглээг сайжруулахтай холбоотой нөлөөллийн ажлыг зохион байгуулах.

9.2.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд дүн шинжилгээ, хяналт, үнэлгээ хийлгэх;

9.2.6. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн дараах судалгаа;

- Хөдөлмөрийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, чадавхжуулах сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа;
- Хүүхдийн мөнгөн тэтгэмж нь хөдөлмөр эрхлэлт, өрхийн амьжиргааны түвшинд хэрхэн нөлөөлөх үр нөлөөг тодорхойлох судалгаа;

---

[32]Хөдөлмөрийн хуулийн 63.3 дагалднаар суралцах ажилтан

[33]Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайдын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/40 дугаар тушаалаар батлагдсан "Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам"-ын хэрэгжилтийг хангах

- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа;
- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийн нөлөөллийн үнэлгээний судалгаа;
- Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт (ҮАМАТ-08)-д нэмэлт өөрчлөлт оруулах, ажил мэргэжлийн профайл боловсруулах./Шинжилгээний үндсэн дээр ажил мэргэжлийн нэршлийг өөрчлөх, давхцлыг арилгах, 150 ажил мэргэжлийн профайл боловсруулах/;
- Үндэсний түвшинд бүтээмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлын шинжилгээ хийж, бодлогын стратеги боловсруулах;

9.2.7. Гарын авлага, маягт, хэвлэмэл материалын эх бэлтгэх, хэвлүүлэх;

9.2.8. Гадаадад ажиллаж амьдарч байгаад эх орондоо эргэн ирсэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, судалгаа мэдээллийг гаргах, Япон, БНСУ болон бусад улс оронд хөдөлмөр эрхэлж буй иргэдийн асуудлаар сурталчилгаа, сургалт, уулзалт, өдөрлөг зохион байгуулах, төрөөс үзүүлж буй үйлчилгээ, арга хэмжээнд хяналт, үнэлгээ;

9.2.9. Улсын хэмжээнд "Старт-Ап" залуу, залуучуудын баг сонгон шалгаруулах арга хэмжээ;

9.2.10. Сангийн яамтай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу төлөх үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр, жижиг зээлийн хүүгийн зардал;

9.2.11. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих.

--- oOo ---

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн
01 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

УЛААНБААТАР ХОТ
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР 2026-2027 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА (ХӨТӨЛБӨР)-НЫ ХҮРЭХ ҮР ДҮН, МЭДЭЭЛЛИЙН БОЛОН ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 1. Хүрэх үр дүн

Үйл ажиллагаа	Үйлчилгээ, арга хэмжээ		Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2025 он	2026 он
					Суурь түвшин	Зорилтот түвшин
1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээллээр хангах үйлчилгээ		1.	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө, мэдээлэл авсан тоо	6,499	23,769
			2.	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалт, зөвлөгөө, мэдээлэл авсан иргэд, байгууллагын тоо	25,000	22,500
	Ажилд зуучлах үйлчилгээ	Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ (Profiling)	3.	ХХҮГ-аар үйлчлүүлсэн ажилгүй эсхүл ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэх иргэдээс профайлинг үйлчилгээнд хамруулсан хүний тоо	9,421	16,685
		Хувь хүний хөдөлмөр эрхлэлтийн төлөвлөгөө боловсруулах	4.	Хөдөлмөр эрхлэлтийн хувийн төлөвлөгөө боловсруулсан хүний тоо	3,873	10,316
		Ажилд зуучлах	5.	Байнгын ажлын байранд зуучлагдсан хүний тоо	11,807	17,138
			6.	Цагийн ажлын байранд зуучлагдсан хүний тоо	607	2,180

2.Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаа	Суурь ур чадварын сургалт		7.	Суурь ур чадварын сургалтад хамрагдсан хүний тоо	5,418	7,500
	Чадамжид суурилсан мэргэжлийн сургалт	Танхимын мэргэжлийн сургалт	8.	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	1,322	5,739
		Ур чадварын цахим сургалт	9.	Сургалтад хамрагдсан хүний тоо	674	-
		Ажлын байр дээрх сургалт	10.	Мэргэжлийн сургалтад (үйлдвэрлэл дээрх) хамрагдсан иргэдийн тоо	10	752
	Аж ахуй эрхлэлтийн сургалт	Бизнес санаа хөгжүүлэх, төсөл бичих сургалт	11.	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	3,859	3,000
			12.	Сургалтад хамрагдсан иргэдээс жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсан иргэдийн хувь	55	60
		Бизнес эрхлэх ур чадварын сургалт	13.	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	2,425	1,950
3.Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Иргэнд олгох санхүүгийн дэмжлэг	14.	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хүний тоо	1,571	1,080
		Нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд санхүүгийн дэмжлэг	15.	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан тоо	30	50
		Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг	16.	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан малчин өрхийн тоо	879	1,000
		Мал маллах арга ухаан, малын ашиг шим боловсруулах сургалт	17.	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	704	830

	Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох	Шилдэг “Старт-Ап” залуу, залуучуудын багийг сонгон шалгаруулж, санхүүгийн дэмжлэг олгох	18.	Гарааны бизнесийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан залуучуудын тоо	31	70
		“Старт-Ап” залуучуудад гарааны бизнесийн дэмжлэг, сургалт, зөвлөгөө, менторын үйлчилгээ	19.	Гарааны бизнесийн сургалт, зөвлөгөөнд хамрагдсан залуучуудын тоо	25	30
	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг		20.	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан ахмадын тоо	1,079	755
	Ажил олгогчийг дэмжих	Ажил олгогчид урамшуулал олгох /6 сараас дээш хугацаагаар бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байраар хангасан/	21.	Байнгын ажилтай болсон иргэдийн тоо	33	50
		Ажил олгогчид санхүүгийн дэмжлэг олгох /асрамжийн газраас гарсан, хорих ангиас суллагдсан иргэнийг ажлын байраар хангасан/	22.	Байнгын ажилтай болсон иргэдийн тоо	0	25
	Түрээсийн дэмжлэг үзүүлэх	Ажлын байрны түрээсийн төлбөрийн хөнгөлөлт	23.	Хөнгөлөлтөд хамрагдсан аж ахуй эрхлэгчийн тоо	112	150
4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр	Хөдөлмөр эрхлэлтийн цогц арга хэмжээ		24.	Хамрагдсан хүний тоо	270	300
	Санхүүгийн дэмжлэг	Иргэн	25.	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн тоо	699	496
		Ажил олгогчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх	26.	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо	20	15

эрхлэлтийг дэмжих хөтөлбөр		Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч	27.	Санхүүгийн дэмжлэг авсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тоо	12	10
	Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаа	Аж ахуй эрхлэлтийн сургалт	28.	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	845	836
		Чадамжид суурилсан мэргэжлийн сургалт	29.	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	255	260
	Түрээсийн дэмжлэг	Ажлын байрны түрээсийн дэмжлэг	30.	Ажлын байрны түрээсийн дэмжлэгт хамрагдсан ХБИ-ээс ажлын байраа хадгалсан иргэний эзлэх хувь	14	40
	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ажлын байр бий болгосон	Ажил олгогчид урамшуулал олгох /ХБИ-ийг ажилд авч 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогч/	31.	25-аас доош ажил олгогчийн тоо	18	30
			32.	25 ба түүнээс дээш ажилтантай ажил олгогчийн тоо	3	10
5.Түр ажлын байраар хангах болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа	Мод тарих, ургуулах, арчлах арга хэмжээ		33.	Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо	2,465	3,000
	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ		34.	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлж ажлын байртай болсон иргэдийн тоо	968	1,000
	Ахмадын холбоо, төрийн бус байгууллагын зөвлөх үйлчилгээ		35.	Зөвлөх үйлчилгээ үзүүлсэн холбоо, төрийн бус байгууллагын тоо	38	40
	Хүүхдийн эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээ		36.	Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо /ахмад/	225	250
6.Засгийн газар болон хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр	"Жоб центр" төсөл		37.	Байгуулагдсан төвийн тоо	14	16
	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг ажил олгогчид дагалдуулан суралцуулахад дэмжлэг үзүүлэх		38.	Дэмжлэгт хамрагдсан суралцагчдын тоо	0	90

тодорхойлсон хөтөлбөр, төсөл, үйлчилгээ, арга хэмжээ	Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр	39.	Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо	5,000	5,000
		40.	Хөтөлбөрт хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын тоо	300	250
	“Бизнес инкубацын цогц үйлчилгээгээр бичил, жижиг бизнес, аж ахуй эрхлэгчийг дэмжих” хөтөлбөр хэрэгжүүлэх	41.	Үйлчилгээнд хамрагдсан иргэдийн орлогын өсөлтийн хувь	-	20
	“Ажил турших” хөтөлбөр	42.	Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо	41	500
	“Дагалдан ажиллаж хөдөлмөрт шилжих нь” хөтөлбөр	43.	Хамрагдсан иргэдийн тоо	161	800
		44.	Ажилд зуучлагдсан хүний тоо	22	400
	“Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөр	45.	Нийт ХЭДҮА-нд хамрагдсан иргэдэд залуучуудын эзлэх хувь	35	40
		46.	Залуучуудын ажил мэргэжлийн төлөвлөлт, хөдөлмөрт хандах хандлагын ахицын түвшин	-	70.0%-с дээш
	“Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх” хөтөлбөр	47.	Өрхийн ахицын хувь	-	50
		48.	Ажилд зуучлуулсан хүний тоо	-	3,000
	Хугацаат цэргийн алба хаагчдад мэргэжил эзэмшүүлэх сургалт	49.	Сургалтад хамрагдаж ажилд орсон иргэдийн тоо	-	1,000

--- oOo ---

Хүснэгт 2. Мэдээллийн үзүүлэлт.

Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Үзүүлэлт	
		Нийтлэг	Тусгай
1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийтлэг үйлчилгээ	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ	Хүн амын бүлэг тус бүрээрх хамрагдсан хүний тоо болон зарцуулсан хөрөнгийн хэмжээ, бий болсон ажлын байр /байнгын, түр, цагийн/ - Эрэгтэйчүүд - Эмэгтэйчүүд - Насны бүлгээр - Бага насны хүүхдээ асарч байгаа эцэг, эхчүүд - Байнгын асаргаатай хүн асардаг иргэн - Хөгжлийн бэрхшээлтэй хүн - Ахмад настан - Тэтгэвэрт гарахад бэлтгэгдэж буй иргэн[34]	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдсан хүний тоо - ЕБС-ын суралцагч /аль сургууль, хэддүгээр анги/ - Ажилгүй иргэн - Ажил олоход хүндрэлтэй иргэн - Бусад иргэн
	Ажилд зуучлах үйлчилгээ		Ажилд зуучлах үе шат бүрээрх хамрагдсан хүний тоо - Хөдөлмөр эрхлэх чадварын үнэлгээ хийлгэсэн хүн/A, B, C, D үнэлгээ тус бүрээрх тоо/ - Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулсан хүн - Ажлын байранд бэлтгэх сургалтад хамрагдсан хүн - Ажилд зуучлагдсан хүн /байнгын, цагийн, түр болон бусад/ - Эргэх холбоо тогтоох, дагалдах үйл ажиллагаанд хамрагдсан хүн Ажилд зуучлагдсан хүн хөтөлбөр, арга хэмжээгээр: - “Цагаан алт” үндэсний хөдөлгөөн - “Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх” хөтөлбөр - “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөр - “Хугацаат цэргийн алба хаагчийг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх” хөтөлбөр - “Дагалдан ажиллаж хөдөлмөрт шилжих нь” хөтөлбөр
	Нэгдсэн бүртгэл, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн үйлчилгээ		Мэдээлэл түгээх суваг, хэлбэрийн тоо болон мэдээлэл хүргэх давтамжийн тоо - Цахим хэрэгсэл - Хэвлэл мэдээллийн хэрэгсэл - Олон нийтийн арга хэмжээ - Хэвлэмэл материал
2.Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа	Суурь ур чадварын сургалт		Сургалтад хамрагдсан хүний тоо - Харилцааны зөөлөн ур чадварын сургалт - Хөдөлмөрийн бүтээмжийн сургалт - Цахим хэрэглээний мэдлэг олгох сургалт

[34] Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-5.1.6-д заасан насанд хүрэх дөхсөн иргэн

		- Гадаадаас эх орондоо эргэн ирсэн иргэн - Оюутан /ИДС, МБСБ/ - Төгсөгчид /ИДС, МБСБ, ЕБС/ - Залуучууд - Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа авдаг иргэн - Нийгмийн халамжийн дэмжлэг авч байгаад хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ арга хэмжээнд хамрагдсан иргэн - Малчин - Хорихоос суллагдсан иргэн - Хөдөлмөрийн насанд хүрээд асрамжаас гарсан иргэн - Хохирогч /гэр бүлийн хүчирхийллийн/	- Ажлын байр, бүтээгдэхүүн үйлчилгээний үйлдвэрлэлтэй танилцуулах арга хэмжээ - Богино хугацааны цахим сургалт - Бусад сургалт /ажлын ярилцлага, хүний нөөцийн тест, асуулгад бэлтгэх/ Суурь ур чадварын сургалтад хамрагдсан хүн хөтөлбөр, арга хэмжээгээр: - “Цагаан алт” үндэсний хөдөлгөөн - “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөр - “Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх” хөтөлбөр
	Чадамжид суурилсан мэргэжлийн сургалт		Сургалтад хамрагдах хүсэлт гаргасан хүн /бүртгүүлсэн/-ий тоо - Сургалтанд хамрагдсан хүн - Сургалтын дараа ажлын байртай болсон хүн - Сургалтын дараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаа, арга хэмжээнд холбон зуучилсан хүн /арга хэмжээний төрлөөр/ Танхимын сургалтад хамрагдсан хүн хөтөлбөр, арга хэмжээгээр: - “Цагаан алт” үндэсний хөдөлгөөн - “Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх” хөтөлбөр - “Хугацаат цэргийн алба хаагчийг мэргэшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх” хөтөлбөр
	Аж ахуй эрхлэлтийн сургалт		Сургалтад хамрагдах хүсэлт гаргасан хүний тоо Сургалтад хамрагдсан хүний тоо - Танхимаар - Цахимаар Сургалтын төрлөөрх хамрагдсан хүний тоо - Өмнөх сургалтад хамрагдагч - Дараах сургалтад хамрагдагч - Туршлага судлах арга хэмжээнд хамрагдсан хүний тоо Аж ахуй эрхлэлтийн сургалтад хамрагдсан хүн. Хөтөлбөр, арга хэмжээгээр: - “Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх” хөтөлбөр
3.Санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагаа	Санхүүгийн дэмжлэг олгох		Санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргасан хүн /бүртгүүлсэн/ Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хүний тоо Ажлын байрны тоо

			- Байнгын - Бий болсон ажлын байр Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан давтамж - Анх удаа хамрагдсан хүний тоо - Дахин/давтан/ хамрагдсан хүний тоо Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хүн хөтөлбөр, арга хэмжээгээр: - "Цагаан алт" үндэсний хөдөлгөөн - "Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх" хөтөлбөр
	Ажил олгогчийг дэмжих		Урамшуулалд хамрагдсан ажил олгогч, ажлын байрны тоо Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан ажил олгогч, ажлын байрны тоо
	Түрээс, борлуулалтын дэмжлэг		Түрээсийн дэмжлэгт хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо - Нийт тоо - Ахмадын төвийн тоо - Хүүхэд харах төвийн тоо Түрээсийн дэмжлэгт хамрагдагчдад нийт жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авагчдын эзлэх хувь Борлуулалтын дэмжлэгийн төрлөөрх хамрагдагсдын тоо - Борлуулалтын цэгээр үйлчлүүлэгч - Төрөлжсөн цахим хуудсаар үйлчлүүлэгч - Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан борлуулалт хийсэн иргэн, аж ахуйн нэгж Түрээс, борлуулалтын дэмжлэгт хамрагдсан хүн. Хөтөлбөр, арга хэмжээгээр: - "Цагаан алт" үндэсний хөдөлгөөн - "Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх" хөтөлбөр
4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа	Цогц арга хэмжээ		Арга хэмжээнд хамрагдсан хүний тоо - Арга хэмжээний үе бүрээрх хамрагдагсдын тоо Халамжийн хөдөлмөр эрхлэлтэд хамрагдагсдын тоо - Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо - Ажил олгогчийн тоо
	Санхүүгийн дэмжлэг		Санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлт гаргагчийн тоо /бүртгүүлсэн/ - Иргэн - Төрийн бус байгууллага - Аж ахуйн нэгж Санхүүгийн дэмжлэгт хамрагдагчдын тоо - Иргэн

			- Төрийн бус байгууллага - Аж ахуйн нэгж Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан давтамж - Анх удаа хамрагдагсдын тоо - Дахин/давтан/ хамрагдагсдын тоо Санхүүгийн дэмжлэгээр бий болсон ажлын байрны тоо - Байнгын - Түр - Шинэ ажлын байр - Хадгалагдсан ажлын байр
	Аж ахуй эрхлэлтийн болон хөдөлмөр эрхлэлтийн сургалт		Жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгосны дараах сургалтад хамрагдсан хүний тоо Уулзалт, хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо Туршлага судлах арга хэмжээнд хамрагдсан хүний тоо
	Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг		Түрээсийн дэмжлэгт хамрагдагсдын тоо Түрээсийн дэмжлэгт хамрагдагсдын нийт жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авагсдад эзлэх хувь Борлуулалтын дэмжлэгт хамрагдагсдын тоо Борлуулалтын дэмжлэгт хамрагдагсдын нийт жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авагсдад эзлэх хувь
	Ажил олгогчид үзүүлэх дэмжлэг		Урамшуулалд хамрагдсан Төрийн бус байгууллагын тоо, ажлын байрны тоо Урамшуулалд хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо, ажлын байрны тоо
5.Түр ажлын байраар хангах болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ		Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдагсдын тоо - Эдийн засгийн салбар тус бүрээрх ахмад мэргэжилтэн зөвлөх - Өндөр ур чадвартай, туршлагатай ахмад ажилтан - Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөрийн зөвлөх Зуучлагдсан ажлын байрны тоо - Байнгын ажлын байр - Түр ажлын байр - Цагийн ажил

--- oOo ---

Хүснэгт 3. Чанарын үзүүлэлт.

Үйл ажиллагаа	Үйлчилгээ, арга хэмжээ	Хамрагд-сан хүний тоо	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн
1.Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ	Ажилд зуучлах үйлчилгээ	17,138	Ажлын байранд зуучлагдсан хүний тоо	80%
2.Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа	Чадамжид суурилсан мэргэжлийн сургалт	5,739	Чадамжийн гэрчилгээ авсан иргэдийн хувь	80%
			Сургалтад хамрагдсан хүний тоонд ажлын байртай болсон иргэдийн эзлэх хувь	20%
3.Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Иргэнд олгох санхүүгийн дэмжлэг	1,080	Санхүүгийн дэмжлэг хамрагдсанаар ажлын байртай болсон иргэдийн хувь	90%
	Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох	70	Санхүүгийн дэмжлэг хамрагдсанаар ажлын байртай болсон иргэдийн хувь	90%
	Ажил олгогчийг дэмжих	75	Ажлын байраар хангагдсан иргэдийн хувь	50%
4.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа	ХБИ-ний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц хөтөлбөр	300	Үйлчилгээнд хамрагдсан иргэдээс ажлын байраар хангагдсан иргэдийн эзлэх хувь	40%
	Санхүүгийн дэмжлэг	496	Дэмжлэг авсан ААНБ –д ажлын байраар хангагдсан ХБИ-ийн эзлэх хувь	80%
5.Түр ажлын байраар хангах болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон үйл ажиллагаа	Мод тарих, ургуулах, арчлах	3,000	Мод тарих арга хэмжээнд хамрагдаж түр ажлын байртай болсон иргэдийн тоо	100%
	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	1,000	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлж түр ажлын байртай болсон иргэдийн тоо	100%

-- oOo ---